



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/279

Булган сум

Байр түрээслэх гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.2, 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын 6 дугаар цэцэрлэгийн барилга нь мэргэжлийн байгууллагын улсын байцаагчийн дүгнэлтээр 2023 оны 10 дугаар сараас барилгын ашиглалтыг зогсоосонтой холбогдуулан тус цэцэрлэгийн үйл ажиллагааг Булган сумын иргэн М.Оюунбатын 945м3 талбай бүхий барилгад 2024 оны 01 дүгээр сарын 08-аас 2025 оны 01 дүгээр сарын 08 хүртэл нэг сарын 7,000,000 (долоон сая) төгрөгөөр түрээслэх гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т үүрэг болгосугай.

2. Цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагааг хангах, стандарт шаардлагад нийцүүлэх, хүүхдийн сурч хүмүүжих орчныг хангуулахад хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Ганболд)-т даалгасугай.

3. Тус цэцэрлэгийн барилгын түрээсийн зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэн санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ